

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ
ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

1. Хуулийн төсөл:

- 1.1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай
- 1.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- 1.3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- 1.4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай
- 1.5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- 1.6. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай
- 1.7. Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай
- 1.8. Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай
- 1.9. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 1.10. Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- 1.11. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2. Улсын Их Хурлын тогтоолын төсөл:

- 2.1. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай
- 2.2. Засгийн газарт чиглэл өгөх тухай
- 2.3. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай
- 2.4. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

ТАНИЛЦУУЛГА

*Үндэсний баялгийн сангийн тухай
хуулийг дагаж мөрдөх журмын тухай
хуульд нэмэлт оруулах тухай*

Монгол Улсын Засгийн газар ирэх онд эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байгаа билээ.

Хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төсөв хооронд үе шаттай, оновчтой зохицуулалт хийх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Ирэх 2025 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2025 онд 40 байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн орлого нэмэгдэх, бүтээн байгуулалтын төслийг санхүүжүүлэх, төсвийн тэнцэл сайжрах, алдагдал буурах нөхцөл бүрдэнэ.

---оо---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2024 онд 20” гэсний дараа “, 2025 онд 40” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 64 дүгээр тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор тодорхой бүсүүдийг тогтоож, тэдгээрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлон, эдийн засаг болон бизнесийн таатай орчныг бүрдүүлэхээр тусгасан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.1-д "Татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчим баримталж, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих" гэж заасан.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд туссан бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжгүй тул татварын бодлогоор хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байна.

Иймд Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 11.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үйл ажиллагаанаас олох орлогод ногдуулах албан татварыг эхний 5 жилд 90 хувь хөнгөлж, төрөөс татварын дэмжлэг үзүүлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийг боловсрууллаа. Энэхүү татварын хөнгөлөлт эдлэх бүсчилсэн хөгжлийн төслүүдэд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны орлогод үзүүлдэг бусад хөнгөлөлтуүдийг давхардуулан эдлүүлэхгүй байх зохицуулалтыг хуулийн төсөлд мөн тусгасан болно.

Түүнчлэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан боловсруулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх явцад тус хуулийн төсөлтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүдээс гарсан саналуудыг хуулийн төсөлд тусгалаа. Хуулийн төсөл батлагдсанаар хувийн хэвшил томоохон бүтээн байгуулалт хийх идэвх санаачилга нэмэгдэж, шинээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг урагшлуулах, цаашлаад бус нутгийн эдийн засгийн онцлогт нийцүүлэн хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр баталсан Аж ах ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн этгээд болон асрамж, халамжийн байгууллагын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн татварын хөнгөлөлт нь одоо хүчин

төгөлдөр мөрдөгдөж буй татварын дэмжлэгтэй давхардаж, зөрчил үүсэж болзошгүй тул Төсвийн байнгын хорооноос энэ асуудлыг нэг мөр цэгцлэх асуудлыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэхийг чиглэл болгосон. Иймд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18, 15.1.19 дэх заалтыг хүчингүй болгон 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт заасан татварын дэмжлэгтэй нэгтгэн томьёолохоор хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн, Монгол Улс Европын холбооны “Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгийн жагсаалт”-аас гараад Татварын суурийг бууруулах, ашиг шилжүүлэх явдлын эсрэг (“BEPS”) байгууллагын 13 дугаар дүрэмд заасан Улс бүрээр үнэ шилжилтийн тайлантай холбоотой олон улсын стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд улс бүрээр үнэ шилжилтийн гаргах үүрэгтэй үндэстэн дамнасан корпорациын орлогын босго олон улсын стандарт 750 сая еврог тухайн үеийн ханшаар хөрвүүлэн 1.7 их наяд төгрөг гэж хуульд тусгасан билээ. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (OECD)-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу дээрх мэдээллийг татварын албаны цахим хуудсаар олон нийт, татвар төлөгчдөд мэдээллэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

---о0о---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

АЖ АХҮЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/22 дугаар зүйлийн 22.5.22 дахь заалт:

“22.5.22.албан татвар төлөгчийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 11.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жилийн хугацаанд 90 хувиар.”

2/22 дугаар зүйлийн 22.9.11 дэх заалт:

“22.9.11.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагаа.”

3/22 дугаар зүйлийн 22.14 дэх хэсэг:

“22.14.Энэ хуулийн 22.5.22-т заасан хөнгөлөлтийг мөн хуулийн 22.1, 22.5-д заасан үйл ажиллагааны орлогод үзүүлэх бусад хөнгөлөлттэй давхардуулан эдлэхгүй.”

4/27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг:

“27.11.Энэ хуулийн 27.1.6-д заасан гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийг холбогдох олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид үндэслэн тооцож, зөвлөмжийн хамтаар татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өөрийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.”

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “Монголын үндэсний олимпын хорооны” гэснийг “Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны” гэж, 26 дугаар зүйлийн 26.15 дахь хэсгийн “22.5.16-д” гэснийг “22.5.16, 22.5.22-т” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.6 дахь заалтын “1.7 их наяд” гэснийг “750 сая евротой тэнцэх” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18, 15.1.19 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.9.11 дэх заалтыг 2035 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.22 дахь заалт, 3 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.14, 22.15 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 26.15 дахь хэсгийн өөрчлөлтийг 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тариф, гаалийн татварын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтооолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 5.3-т бүсийн хөгжлийн бодлогод нийцсэн татварын бодлого хэрэгжүүлэхээр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.1-д татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчим баримталж, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газраас бус бүрийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд төрөлжсөн болон дэд тэргүүлэх чиглэлтэй байхаар төлөвлөн 2024-2028 онд бүсчилсэн хөгжлийн реформын цогц асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна. Уг реформын хүрээнд хийгдэх бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын ажлыг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр хийх боломжгүй тул хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байна.

Түүнчлэн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засгийн газраас 2030 он гэхэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлэн, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба өнгөрсөн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж ирсэн. Цаашид эдийн засгаа төрөлжүүлэх алхмуудыг хийж, боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай байна.

Иймд хувийн хэвшлийг бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг сэдэлжүүлэн, урамшуулах, түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Засгийн газрын шийдвэрээр НӨАТ төлөх хугацааг сунгасан бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн, техник, эдийн засгийн үндэслэл бүхий томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдлийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр тусгалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан боловсруулсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх явцад тус хуулийн төсөлтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүдээс гарсан саналуудыг хуулийн төсөлд тусгасан болно.

Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн татварын хөнгөлөлт үзүүлэх салбарын хувьд алслагдсан орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд үзүүлдэг албан татварын хөнгөлөлтөд хамаардаггүй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.8-д заасан ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул хийх, ашиглах, цөмийн энергийн чиглэлийн үйл ажиллагаа, согтууруулах ундаа болон тамхи үйлдвэрлэх, худалдах, импортлох, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, худалдах, импортлох гэх мэт салбаруудад тус хуулийн төсөлд заасан хөнгөлөлтийг үзүүлэхгүй байхаар тусгасан болно.

---оо---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/38 дугаар зүйлийн 38.1.26 дахь заалт:

"38.1.26.энэ хуулийн 40.8-д заасны дагуу тогтоосон ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмж."

2/38 дугаар зүйлийн 38.4-38.6 дахь хэсэг:

"38.4. Боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдлийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлнө.

38.5. Энэ хуулийн 38.4-т заасны дагуу импортоор оруулсан бараанд тухайн онд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг дараагийн төсвийн жилийн эхний хагас жилд татвар төлөгчид буцаан олгоно.

38.6. Энэ хуулийн 38.4-т Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.8.1-22.8.8-д заасан салбар хамаарахгүй."

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн "чөлөөлөх" гэсний дараа ", хөнгөлөх" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн гарчгийн "чөлөөлөгдөх" гэснийг "чөлөөлөх, хөнгөлөх" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсгийн "гаалийн болон" гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 38 дугаар зүйлийн 38.1.26 дахь заалт, 4 дүгээр зүйлийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 38 дугаар зүйлийн 38.4, 38.5, 38.6 дахь

хэсэг, 2, 3 дугаар зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд тус тус дагаж мөрднө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Хууль хүчингүй болсонд тооцох тухай

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засгийн газраас 2030 он гэхэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлэн, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба өнгөрсөн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж байсан. Цаашид эдийн засгаа төрөлжүүлэх алхмуудыг хийж, бүх төрлийн боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг хангах шаардлагатай байна.

Иймд түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдлийг 2030 он хүртэл импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Дээрх хуулийн төсөлд заасан боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хөнгөлөлтөд хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж хамаарах тул хуулийн давхардал үүсгэхгүй байх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---00---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн шийдвэр, тайлан мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах нь компанийн сайн засаглалын олон улсын суурь зарчим юм. Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын хаалттай байдал нь хуулийн этгээд үр ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн өмч үнэгүйдэх, төрд үүсэх зардлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Иймд төр болон орон нутаг нь тухайн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг нийтийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд ил тод, хараат бус, хөндлөнгийн хяналттай байх, компанийн үйл ажиллагаа ил тод байх зарчмыг бусад хувийн хэвшлийн хуулийн этгээдээс нэмэгдүүлсэн байдлаар хуульчлан үүрэгжүүлэх шаардлага үүсч байна.

Шилэн дансны тухай болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, зарцуулалт, тендерийн баримт бичиг, сонгон шалгаруулалт зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгахаар зохицуулсан бөгөөд үүний зэрэгцээ төрийн өмчит хуулийн этгээдийн онцлогийг харгалзан хүний нөөц, орон тоо, удирдлага хэн болох, тэдгээрийн авч байгаа цалин хөлс, урамшууллын талаарх мэдээлэл болон санхүүгийн ил тод байдал, хувьцааны удирдлага, гэрээ хэлцэл, компанийн өр, зээл, төлбөртэй холбоотой мэдээллийг ил тод байршуулах нь олон нийтийн болон хараат бус, хөндлөнгийн хяналтыг өргөжүүлж, сахилга хариуцлагыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Дээрх зорилтыг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хуулийн этгээдийн дүрэм, засаглалын дотоод журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, аудитын болон санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл, бусдаас авсан дэмжлэг, хандив, тусламж, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх удирдлагын нэр, цалин хөлс, урамшууллын дүн зэрэг мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүлээлгэсэн зохицуулалтыг нэмэлтээр тусгалаа. Тус үүргийг биелүүлээгүй нь хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 211 дүгээр зүйлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүр байгууллагын санхүүгийн төлөв, төлөвлөж байгаа ашиг, хөрөнгө оруулалт, улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг зэрэг мэдээллийг агуулсан зорилтын саналаа боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн хуулийн этгээдийн зорилтын саналыг хянан үзэж, Сангийн яаманд нэгтгэн хүргүүлэхээр заасан боловч түүний хэрэгжилтийг дүгнэж, биелэлтийг хангуулах, үр дүнгийн мөрөөр авах арга хэмжээний зохицуулалт хангалтгүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тайланд дурдсанаар 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 99 хуулийн этгээдийн ашиг, алдагдлыг багцалж авч үзвэл, нийт цэвэр ашгийн дүнгийн 4.75 их наяд төгрөгийг “Эрдэнэс тавантолгой” ХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Эрдэнэс Монгол” ТӨХХК, “Хөдөө аж ахуйн корпорац” ТӨХХК, “Төрийн банк” ХК, 380 тэрбум төгрөгийг бусад 51 хуулийн этгээд бүрдүүлжээ. Харин үлдсэн 43 хуулийн этгээд нь алдагдалтай ажилласан ба алдагдлын нийт дүн 150 тэрбум төгрөг байна.

Түүнчлэн, 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн эрсдэлийн ерөнхий үнэлгээг Олон Улсын Валютын Сангийн ашигладаг санхүүгийн шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож үзэхэд, хөрөнгийн өгөөж “дунд эрсдэлтэй” буюу 0-ээс - 5%-ийн хооронд үзүүлэлттэй 23, “өндөр эрсдэлтэй” буюу -5%-иас доогуур үзүүлэлттэй 20 хуулийн этгээд байна.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд тогтмол ашиггүй ажиллаж, хөрөнгийн өгөөжийн эрсдэлд орсон төрийн өмчит хуулийн этгээдүүдийн давхардсан чиг үүрэг, удирдлага, дэд бүтцийн зардлыг бууруулж, нөөцийг оновчтой хуваарилах, ил тод байдал, хяналтыг сайжруулж үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 3¹-т заасны дагуу эцэслэн тохирсон зорилтын саналын хэрэгжилт гурван жил дараалан хангалтгүй гэж дүгнэгдсэн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд гурван жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн тохиолдолд тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Засгийн газарт санал хүргүүлж шийдвэрлүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төрийн аудитаас гадна шаардлагатай тохиолдолд Засгийн газрын шийдвэрээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх зохицуулалтыг нэмж тусгалаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11, 12, 13, 14 дэх хэсэг нэмсүгэй:

“11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд тухайн төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах саналыг Засгийн газарт хүргүүлнэ:

1/энэ хуулийн 21¹ дүгээр зүйлийн 3¹-т заасны дагуу эцэслэн тохирсон зорилтын саналын хэрэгжилт гурван жил дараалан хангалтгүй гэж дүгнэгдсэн;

2/үйлдвэрлэлийг өргөжүүлэх, технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулснаас бусад тохиолдолд гурван жил дараалан санхүүгийн алдагдал хүлээсэн.

12. Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.

13. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:

1/хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

2/хуулийн этгээдийн зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ, биет, биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

3/хуулийн этгээдийн сүүлийн таван жилд хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

4/хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөө;

5/хуулийн этгээдийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

6/хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ, түүний гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;

7/хуулийн этгээдийн эсрэг, эсхүл хуулийн этгээдтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

8/хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон засаглалын дотоод журам;

9/тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын мэдээлэл, хэрэгжилтийн байдал;

10/бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын болон нийлүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, хэрэгжилтийн явц;

11/Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

12/байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;

13/тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;

14/төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, хандив, тусламж.

14.Энэ зүйлийн 13 дахь хэсэгт заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах үүргийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд тусгана.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“79 дүгээр зүйл.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрх

Орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн 14, 16, 17, 21 дүгээр зүйл, 21¹ дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн
зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан. Үг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин боловсруулахад төсөв алдалдалгүй байх зарчим баримталж, хэрэгжиж эхлээгүй зарим хөтөлбөр, арга хэмжээг зогсоох хүрээнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг 16-18 насны иргэнд жил бүр олгох талаар зохицуулсан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг бүхэлд нь, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болгох хуулийн төсөл боловсрууллаа.

---о0о---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗҮЙЛ, ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг
хүчингүй болсонд тооцох тухай

Зөрчлийн тухай хуулийн 9.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоохтой холбогдсон журмыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийг бүхэлд нь, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болгох хуулийн төсөл боловсруулсантай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 9.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болгох хуулийн төсөл боловсрууллаа.

---0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 9.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Соёлын тухай хуулийн зарим хэсэг,
заалт хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан. Үг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин боловсруулахад төсөв алдалдалгүй байх зарчим баримталж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад тусгагдсан “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих”, “Бүх нийтийн соёлын боловсрол”, “Соёл урлагийг хөгжүүлэх” арга хэмжээний төсөв хасагдаж байгаатай холбогдуулан Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---ооо---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.3.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын тусгай сангийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан. Уг тогтооюор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин боловсруулахад төсөв алдалдалгүй байх зарчим баримталж Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих санг татан буулгахтай холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---00---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Кино урлагийг дэмжих сан,” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “5.3.13,” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.9, 5.3.13 дахь заалт, 13 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Тарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Кино урлагийг дэмжих тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин боловсруулахад тесөв алдалдалгүй байх зарчим баримталж Кино урлагийг дэмжих санг татан буулгаж байгаатай холбогдуулан Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөлд Кино урлагийг дэмжих сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийг зохион байгуулах үүргийг Кино урлагийн зөвлөлд хариуцуулах, мөн Кино урлагийг дэмжих сангийн харилцааг зохицуулсан дөрөвдүгээр бүлгийг бүхэлд нь хүчингүй болгохоор тусгасан болно.

---00---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.16.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.16.5.Кино урлагийг дэмжих сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх, зээлийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх; ”

2 дугаар зүйл.Кино урлагийг дэмжих тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн хэмнэлтийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2024 оны 21-р тогтоолоор Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Одоогоор нийт 50 үндэсний зөвлөл, хороо, комисс байгуулагдсан ба бүрэлдэхүүнд нь төрийн өндөр болон төсөвт байгууллагын удирдах албан тушаалтнууд орж байна.

Эдгээр албан тушаалтанд үндсэн цалин хөлс олгохоос гадна байгууллагаа төлөөлж үндэсний зөвлөл, комисст орж ажилласны урамшуулал болгож жилд 6.6 тэрбум төгрөг олгож байгааг танах зорилгоор үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглох агуулга бүхий заалтыг хуулийн төсөлд тусгав.

Түүнчлэн байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх, төрийн байгууллагууд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, хэрэв зохион байгуулах шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд эсхүл цахимаар зохион байгуулах талаар хуулийн төсөлд тусгав. Ингэснээр заалны түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх боломжтой.

Мөн төрийн албан хэрэг хөтлөлтөд цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгав.

---оо---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2. Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулалт олгохыг хориглоно.”

2/15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалт:

“15.1.8. байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах.”

3/15 дугаар зүйлийн 15.2.7 дахь заалт

“15.2.7. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.”

2 дугаар зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.2.4. цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх.”

3 дугаар зүйл. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “15.1.4-т” гэснийг “15.1.4, 15.1.8-д” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилтуудыг үндэслэн "Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилт 2-т "Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна" гэж заасан. Үүний дагуу Засгийн газрын зүгээс Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлж, боломжит хэмжээг дотоод эх үүсвэрээр төлж барагдуулах стратегийг тогтмол авч хэрэгжүүлж байгаа бөгөөд 2021-2024 онд нийт 2.0 тэрбум ам.долларын бондын төлбөрийг шийдвэрлэж, үүнээс 413.3 сая ам.долларын үндсэн төлбөрийг дотоод эх үүсвэрээс төлж барагдуулаад байна.

Түүнчлэн, "Номад", "Сенчири-1", "Сенчири-2" бондын үндсэн төлбөрт 2026-2028 онд нийт 1,728.0 сая ам.долларын төлбөр төлөгдөх хуваарьтай байгаа нь төсөв, төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөцөд дарамт учруулах эрсдэлтэй байна. Иймд Засгийн газрын зүгээс 2025 онд 1.0 тэрбум ам.доллар хүртэл өрийн зохицуулалтын арга хэмжээг олон улсын зах зээлийн таатай нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хүрээнд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Гадаад өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь Засгийн газрын гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлэхгүй бөгөөд гадаад валютын албан нөөцөд ирэх дарамтыг бууруулах ач холбогдолтой болно.

Түүнчлэн, дээрх стратегийн баримт бичгийн зорилт 4-т "Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийн дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна." гэж заасны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, жишиг хүүг тогтоох, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор 300 тэрбум төгрөг хүртэл Засгийн газрын дотоод үнэт цаасыг арилжаалж эхлэхээр төлөвлөөд байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2025 онд Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.4-т заасан зориулалтаар 1.0 тэрбум ам.доллар хүртэлх гадаад үнэт цаас, Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан зориулалтаар 300.0 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т олгосугай.

2. Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газарт чиглэл өгөх тухай
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр хэвээр, төр аж ахуйн шинжтэй үйл ажиллагааг хувийн хэвшилтэй зэрэгцэн төрийн өмчит компани, үйлдвэрийн газар байгуулах замаар эрхэлж байгаа нь үр ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө үнэгүйдэх, төрд үүсэх зардлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Иймд төрийн өмчит компаниудын засаглалыг олон улсын сайн жишигт нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг хараат бус, мэргэжлийн экспертуудээс бүрдүүлэх, ил тод байдал, сахилга батыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дээрх шаардлагыг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээний үндсэн дээр хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авах, төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд худалдах үндсэн чиглэлийн талаар холбогдох санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар тусгалаа.

Түүнчлэн, Засгийн газраас хэрэгжүүлж буй ногоон хөгжлийн бодлогыг эрчимжүүлэх хүрээнд Төрийн банк болон төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй төсөл хөтөлбөр, хэрэглээг урамшуулан

дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хуртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглүүлэхээр төсөлд тусгалаа.

Мөн нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд төрийн зарим байгууллагуудыг нийслэл хотоос нүүлгэн шилжүүлэх талаар Засгийн газарт өгөх чиглэлийг тусгав.

---00---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төсөв, санхүү, татварын орчныг боловсронгуй болгож олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, цаашид өөрчлөгдөхгүй байх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, шилжилт хөдөлгөөн, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн төрөлжсөн цахим сан бүрдүүлж, улсын бүртгэлийн байгууллага татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

2/нэмэгдсэн өртийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийх, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, саналаа 2025 оны 01 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах;

2/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үр

ашгийг сайжруулах, зардлыг бууруулах асуудлыг судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авах;

3/Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;

5/Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

6/Төрийн банк болон санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчиний хэмнэлттэй төсөлт хөтөлбөр, хэрэглээг урамшуулан дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх.

3. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, бус, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуулийг Хөшгийн хөндийд, Хөдөө, аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийг Дархан хотод нүүлгэн шилжүүлж, хичээлийн байр, оюутны болон багш, ажиллагсдын байр зэргийг цогц байдлаар төлөвлөн сургуулийн хотхон хэлбэрээр байгуулахад шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, багш, ажиллагсдын нийгмийн асуудал, холбогдох урсгал болон хөрөнгийн зардлыг шийдвэрлэх, нүүлгэн шилжүүлэх;

2/Нийслэл Улаанбаатар хотоос шилжүүлэн байршуулах боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид нүүлгэх, нийслэл Улаанбаатар хотод чөлөөлөгдөх барилга, байгууламжийг худалдах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/хот төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оршин суууч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг хийх;

4/инновац шингэж шинээр бүтээгдсэн, олон улсад туршигдсан бараа, материал, барилгын ажил гүйцэтгэх арга барил, тэргүүн туршлагыг барилгын салбарт хурдацтай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор хот байгуулалт,

зураг төсөл, барилгын ажлын стандарт, норм, нормативын баримт бичиг, дүрмийг боловсронгуй болгох ажлыг Барилга байгууламжийн норм, нормативын сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан ба уг хуулиар Олон улсын ургамал хамгааллын конвенцоор хүлээсэн үүргийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажиллахаар зохицуулсан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" хэсэгт "Ургамал хамгааллын газар"-ыг нэмэхээр "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвржуулах, байгаль, цаг уурын болон бусад болзошгүй эрсдэлээс хамгаалах, бүтээгдэхүүний чанарт эергээр нөлөөлж ургацын хэмжээг нэмэгдүүлэн улмаар хүн амын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлэх ба нөгөө талаас импортын болон эх орны төмс, хүнсний ногоонд пестицидийн үлдэгдэл хэмжээ, хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийн үнэлгээг үнэлэх судалгаа шинжилгээний ажлыг орчин үеийн шаардлага хангасан багаж төхөөрөмж, олон улсын аргачлалын дагуу үнэн зөв хийж, хэрэглэгчдийг шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах ач холбогдолтой гэж үзэж байна.

---00---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Ургамал хамгааллын газар” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай
хууль батлагдсантай холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай Улсын Их
Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин боловсруулахад төсөв алдалдалгүй байх зарчим баримтлан урсгал зардлыг бууруулж байгаатай холбогдуулан төсөвт хэмнэлт хийх талаар Засгийн газарт чиглэл өгөх агуулга бүхий Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулав.

Тогтоолын төсөлд тавилга худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүнд ажлын хөлс, урамшуулалт олгох зардлыг 100 хувь, зарим байгууллагын тээвэр шатахууны зардал, гадаад албан томилолт болон зочин телөөлөгч хүлээн авах зардал, дадлага, бэлтгэл сургуулилт, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг 50 хувиар, мөн бүх төсөвт байгууллагын бараа худалдан авах болон гуравдагч этгээдэд төлөх үйлчилгээ, татаас, шилжүүлгийн зардлыг 10 хувиар бууруулахаар тооцов.

Түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон тариф, мөнгөн хэмжээ, норматив тогтоосон шийдвэрийг өөрчлөх, орц болон гарцыг багасгах, хамрах цар хүрээг хумьж хяналтын тоог бууруулах, ач холбогдоор нь эрэмбэлж хэрэгжилтийг хойшлуулах, үйл явцын дахин инженерчлэл хийж үр ашгийг сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зэргээр зарим арга хэмжээний зардлыг 10 хувь бууруулахаар тооцов.

---ооо---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ
ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төсвийн байгууллагын урсгал төсвийг хэмнэх чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:

1/бүх шатны төсвийн байгууллагын тавилга худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биений тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүнд ажлын хөлс, урамшуулалт олгох зардлыг 100 хувь бууруулах;

2/эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын гадаад албан томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл сургуулилт хийх зардал, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулах;

3/энэ тогтоолын 1.1, 1.2-т зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээ, татаас, шилжүүлгийн зардлыг 10 хувиар бууруулах;

4/ур ашиггүй давхардсан чиг үүрэг бүхий ажлын алба, орон тоог цомхотгох, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх,

5/тариф, мөнгөн хэмжээ, норматив тогтоосон шийдвэрийг өөрчлөх, орц болон гарцыг багасгах, хамрах цар хүрээг хумъж хяналтын тоог бууруулах, ач холбогдоор нь эрэмбэлж хэрэгжилтийг хойшлуулах зэргээр доор дурдсан арга хэмжээний зардлыг 10 хувь бууруулах:

а/боловсролын салбарын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдан авах, гадаад дотоодын их дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох

сургуулийн суралцагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах;

б/улсын төсвийн санхүүжилтээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хүн амыг дархлаажуулах, дадлагажигч эмч бэлтгэх, нийгмийн эрүүл мэндийн тандалт судалгаа хийх, халдварт болон халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, шүд, амны хөндийн үзлэг, эмчилгээ хийх, гадаад улс оронд эмчлүүлэхэд зардлын дэмжлэг үзүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, эрүүл мэндийг дэмжих, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, эрдэм шинжилгээний судалгаа, тандалт хийх;

в/малыг вакцинжуулах, хөдөө аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлэх, урамшуулал, зээлийн хүүгийн татаас олгох, улсын нөөцийн барааг сэлгэн бүрдүүлэх, геологийн хайгуул хийх, агаарын бохирдлыг бууруулах, ойжуулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх;

г/цахим шилжилт хийх, мэдээлэл сурталчилгаа хийх, улсын баяр наадам зохион байгуулах, спортын өндөр амжилт гаргасан тамирчинд шагнал, урамшуулал олгох, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт урамшуулал олгох, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагч нарт тэтгэмж олгох, орон нутгийн өмчид их засвар хийх.

6/нийгмийн халамжид хамрагдах шалгуурыг оновчтой болгох, хөнгөлөлт үйлчилгээний давхардлыг арилгах, халамжаас хөдөлмөрт шилжих хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр нийгмийн халамжийн сангийн зардлыг 1.3 хувиар бууруулах;

7/Салбарын яам, агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг нь хэрэгжүүлэх бүрэн боломжтой үндэсний хороо, зөвлөл, комиссын ажлын албыг татан буулгаж чиг үүргийг холбогдох байгууллагад шилжүүлэх;

8/улсын төсвөөс Дундговь, Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, Төв, Өмнөговь, Говьсүмбэр, Дорнод, Ховд, Хэнтий, Сэлэнгэ аймагт олгодог усан хангамжийн татаасыг тэглэх;

2.Статистикийн тухай хуульд заасан сэдэвчилсэн тооллого, судалгааны үр дүнг ерөнхий байдлаар тоймлох зэргээр үйл ажиллагааны зардлаа хэмнэж ажиллахыг Үндэсний статистикийн хороо (Б.Батдаваа)-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Төсвийн байнгын хороо (Ц.Даваасүрэн)-д даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг